



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар A/72

Улаанбаатар хот

Стандартчиллын техникийн болон дэд
хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 25 дугаар зүйлийн 25.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стандартчиллын техникийн болон дэд хороодын бүрэлдэхүүнийг 1-ээс 64 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/158, 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/108, 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/06, 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/77, 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/78, 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/90, 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/147, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/129, 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/130, 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/41, 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/62, 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар баталсан Стандартчиллын техникийн болон дэд хороодын бүрэлдэхүүнийг хүчингүйд тооцсугай.

3. Техникийн хорооны Дарга, гишүүдээс "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг тухай бүр гаргуулан, Стандартчиллын техникийн болон дэд хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж ажиллахыг Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газар (Д.Даваасүрэн)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.УУГАНБАЯР



130000700

Стандарт, хэмжил зүйн газрын дарын
2023 оны 4-р дүгээр сарын 03-ний өдрийн
АДАГ дугаар тушаалын б1 дүгээр хавсралт



XTY3154 9020030641 9096035

Хөргөлт агааржуулалтын стандартчиллын
техникийн хорооны бүрэлдэхүүн (ТХ 49)

Дарга:	Д.Гантулга	Барилга хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Жинхэнэ гишүүд (Р):	Ж.Гэрэл	Эрчим хүчний яамны Бодлого, телевеллтийн газрын шинжээч
	Д.Дуламсүрэн	Байгаль орчин аялал жуулчлалын яамны Озоны үндэсний албаны ахлах мэргэжилтэн бөгөөд төслийн нэгжийн зохицуулагч
	Ц.Мөнхбат	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн
	Ө.Мөнхбаяр	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Салбарын хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч
	Л.Амартувшин	Гаалийн ерөнхий газрын Гаалийн хяналт, шалгалтын газрын улсын байцаагч
	П.Хийморьсайн	Эрчим хүчний зохицуулах хорооны Эрчим хүчний хэмнэлтийн газрын мэргэжилтэн
	М.Оюун-Эрдэнэ	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Эрчим хүчний сургуулийн ахлах багш
	Ц.Өсөөжаргал	Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбооны ерөнхийлөгч
	Ш.Энх-Амгалан	"Мастер чадамж" сургалт судалгааны төвийн тэргүүн, доктор (Ph.D)
	З.Отгон	Шинжлэх ухааны академийн Тархи, сэтгэл судлалын хүрээлэнгийн салбар дундын трансляц инновацийн төвийн дарга
	А.Одгэрэл	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Мэдээлэл, холбооны технологийн технологийн сургуулийн Электроникийн салбарын эрхлэгч